



ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 8/05

Жаргалтхаан сум

О.Түвшинбаярыг ажилд томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 93 дугаар зүйлийн 93.1, 99 дүгээр зүйлийн 99.1, 99.2, 99.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Боловсролын сайдын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Оргилын Түвшинбаяр нь туршилтын хугацаанд төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаагүй, ажлын гүйцэтгэлийн шалгуурыг хангасан тул 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс нийгмийн ажилтнаар томилсугай.

2. О.Түвшинбаярыг ТҮБД-4 дүгээр шатлал, 2338500 (хоёр сая гурван зуун гучин найман мянга таван зуу) төгрөгөөр цалинжуулж, мэргэшлийн тэргүүлэх зэргийн нэмэгдлийг 15 хувиар тооцож, холбогдох нэмэгдэл, урамшууллыг зохих хууль тогтоомж, журмын дагуу олгохыг нягтлан бодогч (Г.Урансүх)-д зөвшөөрсүгэй.

3. Сургуулийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж, багш, ажилтны нийгмийн асуудал, сурагчдын хүмүүжил төлөвшилд анхаарч, холбогдох мэдээ, судалгааг цаг тухайд нь хийж гүйцэтгэх, тайлагнах, сургуулийн дотоод аливаа үйл ажиллагаанд удирдлагын түвшинд оролцож, асуудал тавих, шийдвэрлүүлэх замаар хамтран ажиллахыг нийгмийн ажилтан О.Түвшинбаярт үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "О.Түвшинбаярыг ажилд томилох тухай" захирлын 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Б/48 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



С.ОЮУНЦЭЦЭГ

D/Tushaal-2026

3001003